

ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Шүгэл үлээх орчны талаар өөрийн үнэлгээний аргачлал боловсруулах

1. Зорилго, үндэслэл

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 5.6-д “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.3-т “Авлигатай тэмцэх “5Ш” ажиллагааг үргэлжлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Зорилго 4 буюу Хувийн хэвшил авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлэхэд бизнес эрхлэгчдийн төлөөллийн байгууллага болох Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимтай хамтран ажиллаж байна. Арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.3.3-т **“Компанийн дотоод орчинд шүгэл үлээх орчны талаарх өөрийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, бизнес эрхлэгчдэд түгээх”** арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Хэдийгээр Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл Улсын Их Хурлаар батлагдалгүй хойшлогдсоор байгаа боловч шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулах үйл ажиллагааны хөрс суурь хувийн хэвшилд бүрдээд эхэлжээ. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улсад хөрөнгө оруулахаас өмнө авлигаас урьдчилан сэргийлэх, шүгэл үлээгчийг хамгаалах бодлого, дүрэм журамтай эсэхийг дотоодын аж ахуйн нэгжүүдээс асууж, шаардах болсон. Зарим үндэсний хэмжээний томоохон компаниуд өрсөлдөх чадвараа сайжруулж, бизнесийн нэр хүндээ хамгаалах зорилгын хүрээнд дотооддоо шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулах бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байна. Мөн сүүлийн үед төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд “ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо”-г нэвтрүүлэх хүрээнд шүгэл үлээгчийг хамгаалах дүрэм журмыг батлан хэрэгжүүлэх болов.

2. Хамрах хүрээ

Аж ахуйн нэгжүүдийн дотоод дахь шүгэл үлээх орчны талаарх өөрийн үнэлгээний аргачлал боловсруулах, турших, үнэлгээний аргачлалыг хэрэглэх заавар, зөвлөмж боловсруулах.

3. Зөвлөхийн гүйцэтгэх ажил

- Гадаад болон дотоодын тус бүр 5-аас доошгүй компанийн шүгэл үлээгчийн хамгаалах бодлого, дүрэм журам, тэдгээрийг хэрэгжүүлсэн арга хэлбэрийн талаар судлах, санал, дүгнэлт боловсруулах;

- Компанийн орчинд шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулах орчны өөрийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулах, 2-3 аж ахуйн нэгжид туршиж, аргачлалыг хэрэглэхэд учирч болзошгүй хүндрэл бэрхшээлийг судалж, анхаарах зүйлийг тодорхойлон заавар, зөвлөмж боловсруулах;

- Авлигатай тэмцэх газрын зохион байгуулсан хэлэлцүүлэг, семинарт оролцож, авлигын эсрэг комплаенсын загвар хөтөлбөр, түүнийг нэвтрүүлэх зөвлөмжийн талаар оролцогчдод танилцуулж, санал авах, саналыг загвар хөтөлбөр, зөвлөмжид тусгах;

- Компанийн дотоодод шүгэл үлээх орчны талаарх өөрийн үнэлгээний аргачлал, түүнийг хэрэглэх заавар, зөвлөмж, ажлын тайлангийн хамт хүлээлгэн өгөх.

4. Зөвлөхөд тавигдах шаардлага

- Бизнесийн удирдлага, эрх зүй болон бусад холбогдох нийгмийн шинжлэх ухааны чиглэлийн мэргэжилтэй байх;
- Монгол Улсын засаглалын тогтолцоо, хууль, эрх зүйн талаар ойлголт, мэдлэгтэй байх;
- Судалгааны түвшинд хэрэглэхүйц англи болон бусад гадаад хэлний ур чадвартай байх;
- Засаглал, бизнесийн эрх зүйн чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаанд оролцож, үр дүн гаргасан байвал давуу тал болно.

5. Хүлээлгэн өгөх ажил, хугацаа

Зөвлөхийн гэрээ байгуулагдсанаас хойш 2 сарын дотор хэрэгжүүлсэн ажлын тайлан болон авлигын эсрэг комплаенсын хөтөлбөрийг боловсруулж, зөвлөмжийн хамт хүлээлгэн өгсөн байна.

6. Ажлын хуваарь, ажил гүйцэтгэх газар

Зөвлөх нь дараах хуваарийн дагуу ажиллана.Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Тайлбар
1	Компанийн шүгэл үлээгчийн хамгаалах бодлого, дүрэм журам, тэдгээрийг хэрэгжүүлсэн арга хэлбэрийн талаар судлах, санал, дүгнэлт боловсруулах	20 хоног	Гадаад, дотоодын тус бүр 5-аас доошгүй компанийн туршлага судалсан байна.
2	Компанийн орчинд шүгэл үлээгчийн хамгаалах, урамшуулах орчны өөрийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулах	10 хоног	
3	Явцын тайланг ирүүлж, авлигын эсрэг комплаенсын хөтөлбөр төслийг танилцуулах	1 хоног	Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнууд зөвлөхийн хэрэгжүүлсэн ажилд санал, зөвлөмж өгнө.
4	Ажлын явцын тайлан болон авлигын эсрэг комплаенсын хөтөлбөрийн төсөлд шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийх	5 хоног	
5	2-3 компани дээр турших	15 хоног	Компаниудыг зөвлөхүүд сонгон АТГ болон МҮХАҮТ-д мэдээлэл өгч ажиллана. Шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх газраас дэмжлэг үзүүлж болно.
6	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан хэлэлцүүлэг, семинарт оролцон ажиллах	1 хоног	
7	Авлигын эсрэг комплаенсын хөтөлбөр, зөвлөмж, ажлын тайланг эцэслэх	10 хоног	Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнууд зөвлөхийн ажлыг шалган хүлээж авна.

Зөвлөх нь гэрээнд заасан ажлыг Монгол Улс, Улаанбаатар хотод хийж гүйцэтгэнэ.

Ирүүлэх материал:

- Сонгон шалгаруулалтад орох тухай хүсэлт /Хэрэв байгууллага бол албан бичиг/;

- Судалгаа хийх шинжээчийн CV, диплом, ажлын туршлагын талаарх мэдээлэл;

- Бусад.

/Дээрх материалыг galbadrakh@iaac.mn цахим хаягт 2025 оны 07 дугаар сарын 04-ний дотор хүргүүлнэ./

--oOo--